УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН ТУШААЛ

2018 оны 03 сарын 27 өдөр Дугаар А/75 Улаанбаатар хот

О.Уянгад буцалтгүй тусламж олгох тухай

Төрийн албаны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4.3, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар хэсгийн 2.4.1 дэх заалт, Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүнс худалдаа үйлчилгээний хэлтсийн мэргэжилтэн Отгонбаярын Уянгын эмээ нас барсан тул дотоод журмын 8 дугаар зүйлийн 8.8.1-д заасны дагуу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний буцалтгүй тусламжийг олгосугай.

2. О.Уянгад олгох тэтгэмжийн 480000 /дөрвөн зуун наян мянга/ төгрөгийг тэтгэмж урамшууллын зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Б.Цэрмаа/-д зөвшөөрсүгэй.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА Т.ГАНТӨМӨР

D:\backup_old_pc\Work documents\doc 2018\Тушаал doc 2018.docx

111 3 245